

UCS 1101B:2022

## НИЙГМИЙН ДЭД БҮТЭЦ




Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын  
гадна орчны ерөнхий шаардлага



# НИЙГМИЙН ДЭД БҮТЭЦ

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын  
гадна орчны ерөнхий шаардлага

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2022 оны 19-р тогтоолоор батлав.



## ГАРЧИГ

1. Хамрах хүрээ .....	5
2. Норматив эшлэл.....	5
3. Нэр томьёоны тодорхойлолт .....	5
4. Төлөвлөлтийн ерөнхий шаардлага .....	6
5. Эдэлбэр газар.....	8
6. Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлт.....	10
7. Тоглоомын талбай .....	11
8. Биеийн тамирын талбай .....	13
9. Барилгын гол хаалга, гадна довжоо.....	13
10. Зам, замын байгууламж.....	15
11. Замын хөдөлгөөний аюулгүй байдал .....	16
12. Аюулгүй байдал, камержуулалт.....	19
13. Үерээс хамгаалах, борооны ус зайлцуулах байгууламж .....	19
14. Хашаа, хайс .....	20
15. Зам талбайн гэрэлтүүлэг .....	21
16. Байгууллагын нэрийн тэмдэг, байршлын мэдээлэл.....	22
17. Хог хаягдал цуглуулах цэг .....	23
18. Гамшгаас хамгаалах арга хэмжээ .....	25
19. Хүлээн авах шалгуур үзүүлэлт.....	27
Ашигласан материалын жагсаалт .....	28

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Цэцэрлэгийн барилгын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө харагдах байдал / жишээ/ .....	7
Зураг 2. Цэцэрлэгийн барилгын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө харагдах байдал (Жишээ зураг) .....	7
Зураг 3. Цэцэрлэгийн барилгын гадна орчны харагдах байдал (Жишээ зураг).....	8
Зураг 4. Цэцэрлэгийн барилгын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө (Жишээ зураг) .....	9
Зураг 5. Хүүхдийн цэцэрлэгийн ногоон байгууламжийн төлөвлөлт (Жишээ зураг).....	10
Зураг 6. Хүүхдийн цэцэрлэгийн тоглоомын талбайн харагдах байдал (Жишээ зураг) ...	11
Зураг 7. Шат болон бариулын хэмжээ (Жишээ зураг) .....	14
Зураг 8. Шатны нэмэлт бариулын стандарт (Жишээ зураг) .....	14
Зураг 9. Барилгын орц, гадна довжоо, налуу замын стандарт (Жишээ зураг) .....	15
Зураг 10. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зогсоол, хүртээмжтэй зогсоолын хэмжээ (Жишээ зураг).....	15
Зураг 11. Явган хүний зам (Жишээ зураг) .....	16
Зураг 22. Хяналтын камер тэмдэг (Жишээ зураг) .....	19
Зураг 24. Үерээс хамгаалах борооны ус зайлцуулах байгууламжийн төлөвлөлтийн менежмент (Жишээ зураг) .....	20

Зураг 25. Хашаа хайсны төрөл (Жишээ зураг).....	21
Зураг 26. Гадна орчны гэрэлтүүлэг (Жишээ зураг) .....	22
Зураг 27. Байгууллагын нэрийн тэмдэг (Жишээ зураг).....	22
Зураг 28. Байгууллагын нэрийн бичвэр (Жишээ зураг) .....	23
Зураг 29. Хог хаягдал цуглуулах цэг (Жишээ зураг) .....	24
Зураг 30. Ангилан ялгах тэмдэг бүхий хогийн сав (Жишээ зураг) .....	24
Зураг 36. Түр цугларах аюулгүй талбай тэмдэг, суурилуулах схем .....	26

## **ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт 1. Эдэлбэр газрын хэмжээ .....	8
Хүснэгт 2. Эзэмшил талбайд мод, бут, сөөг тарих хэмжээний үзүүлэлт .....	10
Хүснэгт 3. Гал унтраах анхан шатны багаж .....	25
Хүснэгт 4. Шалгуур үзүүлэлт .....	27



## НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

Г Нийгмийн дэд бүтцэд хамаарах  
хотын стандартыг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт; Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэг, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн  $10^1$  дүгээр зүйлийн  $10^1.1$  дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн Нийгмийн дэд бүтэц бүлэгт хамаарах дор дурдсан стандартуудыг хавсралтаар баталсугай. Үүнд:

1.1.UCS1101B:2022 “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын гадна орчны ерөнхий шаардлага” хотын стандарт

1.2.UCS1102B:2022 “Ерөнхий боловсролын сургуулийн гадна орчинд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

1.3.UCS1103B:2022 “Эрүүл мэндийн байгууллагын гадна орчны ерөнхий шаардлага” хотын стандарт

1.4.UCS1104B:2022 “Төрийн байгууллагын гадна орчны ерөнхий шаардлага” хотын стандарт

2. Батлагдсан хотын стандартуудыг мөрдүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д даалгасугай.

3. Энэхүү тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.



1110100313



## UCS 1101B:2022 “СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН ГАДНА ОРЧНЫ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА” ХОТЫН СТАНДАРТ

### 1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү стандартыг сургуулийн өмнөх боловсролын байгууллагын гадна орчныг тохижуулахад дагаж мөрдөнө.

### 2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандарт нь эш татсан дараах хууль, барилгын норм ба дүрэм, стандартын шаардлагыг бүрэн хангах бөгөөд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалыг үндэслэл болгоно.

- Боловсролын тухай хууль;
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль;
- БНБД 30.01.04 Хот тосгон төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм;
- БНБД 31.03.03 Олон нийт, иргэний барилгын норм;
- MNS 6558:2015 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчин. Ерөнхий шаардлага;
- Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчны стандартыг хэрэгжүүлэх зэвлөмж – БСШУЯ, Unicef НҮБ-ын Хүүхдийн сан;
- UCS 1410B:2022 бүрэн гудамж, хашаа хайс, хашлаганд тавих ерөнхий шаардлага;
- UCS 0901B:2022 Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт угсралтад тавих шаардлага;
- UCS 0903B:2022 Унадаг дугуйн замын төлөвлөлт, хучилтад тавих шаардлага;
- UCS 0902B:2022 Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөх, байгуулахад тавих ерөнхий шаардлага.

### 3. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

**Сургуулийн өмнөх боловсрол** – гэж бүх нийтийн анхдагч шат, хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд орох хүртэлх хугацаанд хөгжүүлэн төлөвшүүлэхэд чиглэсэн мэдлэг, чадвар, дадал, үнэт зүйлсийн тогтолцоо;

**Сургалтын орчин** – гэж боловсролын стандарт, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах материаллаг нөхцөл;

**Эзэмшил газар** – гэж хүүхдийг хөгжүүлж, төлөвшүүлэх зориулалтаар ашиглаж байгаа газар;

**Тусгай цэцэрлэг** – гэж хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих сургалтын байгууллага;

**Сувиллын цэцэрлэг** – гэж хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насын биеийн өсөлт, оюун ухааны хөгжлийн хоцрогдолтой хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих сургалтын байгууллага;

**Асрамжийн цэцэрлэг** – гэж хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насын эцэг, эх, асран хамгаалагчгүй болох нь албан ёсоор тогтоогдсон өнчин, хагас өнчин хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих сургалтын байгууллага;

**24 цагийн ажиллагаатай цэцэрлэг** – гэж эцэг, эх, асран хамгаалагчийн хүсэлтийн дагуу орон нутгийн засаг захиргаа, мэргэжлийн байгууллагын хамтарсан шийдвэрээр ажлын таван өдөр тасралтгүй үйл ажиллагаа явуулж буй цэцэрлэг болон бүлгийг;

**Халамжийн цэцэрлэг** – гэж Нийгмийн халамжийн тухай хуулийн З дугаар зүйлийн 3.1.1-д заасан хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насын хүүхдийг асрах, хамгаалах, хөгжүүлэх цогц үйл ажиллагаа бүхий сургалтын байгууллага;

**Салбар бүлэг** – гэж хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насын хүүхдийг цэцэрлэгт түшиглэн эцэг, эх, асран хамгаалагчийн хүсэлтийн дагуу цэцэрлэгийн зөвлөлийн шийдвэрээр эрүүл, аюулгүй, хамгаалагдсан, стандартад нийцсэн сургалтын орчин бүхий хүүхдийг асрах, хамгаалах, хөгжүүлэх үйл ажиллагаа.

#### **4. ТӨЛӨВЛӨЛТИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА**

4.1 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын гадна орчны нэгдсэн стандартад нийцсэн төлөвлөлтийн орчин бий болгоход холбогдох хууль тогтоомж, норм дүрмийн дагуу иж бүрэн авч үзэх шаардлагатай.

4.2 Цэцэрлэгийн эзэмшил газарт хүүхдийн аюулгүй тоглох, сурч хөгжих нөхцөлийг бүрдүүлсэн дараах иж бүрдэл, тохижилтын элементүүдийг байршил, барилгын онцлогтой нь уялдуулан төлөвлөнө.

- 4.2.1 Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлт;
- 4.2.2 Тоглоомын болон биеийн тамирын талбай;
- 4.2.3 Барилгын гол хаалга, шат довжоо;
- 4.2.4 Зам, замын байгууламж;
- 4.2.5 Аюулгүй байдал, камержуулалт;
- 4.2.6 Үерээс хамгаалах, борооны ус зайлцуулах байгууламж;
- 4.2.7 Хашаа, хайс;
- 4.2.8 Хаяг, хаягжилт, гэрэлтүүлэг чимэглэл;
- 4.2.9 Хог хаягдал;
- 4.2.10 Галын аюулгүй байдал;

4.3. Гадна орчны тохижилтын барилгын ажлыг “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах” тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгж байгууллагын боловсруулсан, холбогдох хууль тогтоомж, норм, дүрэм, журам, энэхүү хотын стандартад нийцсэн, эрх бүхий байгууллагаар батлуулсан ажлын зураг төслийн дагуу гүйцэтгэнэ.



Зураг 1. Цэцэрлэгийн барилгын хэсэгчилсэн өрөнхий төлөвлөгөө харагдах байдал /жишээ/



Зураг 2. Цэцэрлэгийн барилгын хэсэгчилсэн өрөнхий төлөвлөгөө харагдах байдал (Жишээ зураг)




Зураг 3. Цэцэрлэгийн барилгын гадна орчны харагдах байдал (Жишээ зураг)

## 5. ЭДЭЛБЭР ГАЗАР

- Цэцэрлэгийн эзэмшил газрын талбайн 50 хувиас доошгүй хэсэг нь ногоон ургамлаар бүрхэгдсэн байх бөгөөд үлдсэн 50 хүртэлх хувь нь цардаж зассан хатуу хучилттай замтай байна.
- Эдэлбэр газрын хөрс тэгш, цэвэр, хуурай, хөрсний доорх ус нь аль болох гүнд ба гадарга нь төвгөр, цас, борооны ус тогтохооргүй байх шаардлагатай.
- Нэг хүүхдэд ногдох эдэлбэр газрын хэмжээг Хүснэгт 1-т үзүүлэв.

Хүснэгт 1. Эдэлбэр газрын хэмжээ

№	Хүчин чадал /Хүүхдийн тоо/	Нэг хүүхдэд ногдох талбай /м <sup>2</sup> /	Эдэлбэр газрын хэмжээ /м <sup>2</sup> /
1	90 хүртэл	35	3150-аас багагүй
2	140-320 хүртэл	30	2700-аас багагүй
3	560-640 хүртэл	30	1600-19200-аас багагүй



Зураг 4. Цэцэрлэгийн барилгын хэсэгчилсэн өрөнхий төлөвлөгөө (Жишээ зураг)

№	ТОДОРХОЙЛОЛТ
1	Хог хаягдлын хэсэг
2	Одоо байгаа барилга
3	Цэцэрлэгийн барилга
4	Олон төрлийн үйл ажиллагаа явуулах зориулалт бүхий задгай талбай
5	Хүүхдийн тоглоомын талбай
6	Сүүдрэвч амрах хэсэг
7	Ногоон байгууламж /зүлэгжүүлсэн талбай/
8	Биеийн тамирын талбай
9	Аж ахуйн барилга
10	Авто зогсоол
11	Хурд сааруулагч

## 6. НОГООН БАЙГУУЛАМЖ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТ

6.1. Хүүхдийн цэцэрлэгийн ногоон байгууламж нь дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- 6.1.1. зүлэгжүүлсэн талбай;
- 6.1.2. мод, бут, сөөг;
- 6.1.3. цэцэгт байгууламж.

6.2. Цэцэрлэгийн эзэмшил газарт мод, бут, сөөгийг тарихдаа хүснэгт 2-т заасан хэмжээг баримтлан хаана, ямар мод тарихаа сонгоно.

*Хүснэгт 2. Эзэмшил талбайд мод, бут, сөөг тарих хэмжээний үзүүлэлт*

Хоорондын зай	Хэмжээ	
Шилмүүст болон навчит модны хоорондох зай	3-4	м
Бут, сөөгийн хоорондох зай	0,7-1,5	м
Модны эгнээ хоорондын зай	2,5-4	м
Бут, сөөгийн эгнээ хоорондын зай	1-1,5	м

6.3. Модыг барилгын цонхноос 10 м-ийн зайд, бут, сөөгийг 5 м-ээс доошгүй зйттай тарьж суулгана (БНБД 66-88).



*Зураг 5.Хүүхдийн цэцэрлэгийн ногоон байгууламжийн төлөвлөлт (Жишээ зураг)*

- 6.4. Цэцэрлэгжүүлэлтийн зориулалт болон нар, салхины нөлөөлөл, агаарын бохирдолт, хөрсний нөхцөл зэрэг тухайн нөхцөл байдалтай уялдаатайгаар мод, сөөгийн нэр төрөл, тарих хэлбэрийг сонгон авна. (БНБД 30-01-04).
- 6.5. Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийг хийхдээ тухайн орчны болон барилга байгууламжийн загвар, дизайн, өнгө үзэмжид оновчтой тохируулан тохижуулах бөгөөд холбогдох норм, дүрэм, стандартын шаардлагыг дагуу гүйцэтгэнэ.
- 6.6. Хүүхдийн цэцэрлэгийн хашааг тойруулан шар хуйас, хайлаас зэрэг чимэглэлийн мод бутыг тарихаас гадна жимсний бутыг бүл үүсгэж тарьж болно.
- 6.7. Цэцэрлэгийн эзэмшил газар нь хүртээмжтэй, том талбайтай бол цэцэгт байгууламжийг байгуулж болно.

## 7. ТОГЛООМЫН ТАЛБАЙ

- 7.1. Хүүхдийн цэцэрлэгийн эзэмшил газарт хүүхдийн хөгжлийн онцлог, хэрэгцээ, сонирхолд нийцсэн, хөдөлгөөнийг дэмжсэн тоглоомуудыг байрлуулна. Тоглоомын талбайн тоглоом, тоног төхөөрөмжид дараах нийтлэг шаардлага тавина. Үүнд:
- 7.1.1. тоглоом, тоног төхөөрөмж тус бүрийн эрүүл, аюулгүй байдлыг хангах;
  - 7.1.2. зөөврийн тоглоом, биеийн тамирын тоног төхөөрөмжийг ашиглахдаа хүүхдийн бие мах бодод гэмтэл учруулахгүй байхаар тогтвортой байршуулах;
  - 7.1.3. гулсуур, авирах шат, дүүжин, савлуур зэрэг тоглоомоор тоглох, дугуй унах, цас мөсөн дээр гулгах үеийн аюулгүй байдлыг хангах;
  - 7.1.4. тоглоомын талбайд элс, зөөлөвч шал, зүлэг, угаасан хайрга зэрэг зөөлөн гадаргуутай хамгаалалт хийж хүүхдийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах;
  - 7.1.5. тоглоомын талбайн тоглоомуудад тогтмол хяналт тавьж, гарсан эвдрэлийг засан сэлбэж, хүүхэд бэртэж гэмтэхээс сэргийлэн аюулгүй байдлыг хангах.
- 7.2. Тоглоом, биеийн тамирын талбайн тохижилт, тоноглолын их засвар хийх жишиг хугацаа 4 жил байна.



Зураг 6. Хүүхдийн цэцэрлэгийн тоглоомын талбайн харагдах байдал (Жишээ зураг)

- 7.3. Сургууль, цэцэрлэгийн цогцолборын эзэмшил газарт бага насны хүүхдийн тоглох талбайг тусад нь байгуулна.
- 7.4. Хүүхдийн тоглоомын талбайд сүүдрэвч, гулсуур, дүүжин, элсээр тоглох талбай, савлуур зэрэг суурин тоглоом байх.
- 7.5. Суурин тоглоомыг хөдөлгөөнгүй суурилуулж, суурь хэсэгт нь зөөлөн шалавч байрлуулна.
- 7.6. Тоглоомын гадаргуу нь хурц ирмэг, ил цухуйсан эрэг шураггүй .

- 7.7. Тоглоомын талбайд байрлуулах тоглоомын төхөөрөмж, эд анги, шат, тавцан зэрэг нь тээглэх, гогоолдох аюул, эрсдэлийг дагуулдаг тул урьдчилан сэргийлэх, модон материалыаар хийсэн тохиолдолд өргөснөөс сэргийлж сайтар зүлгэж өнгөлөх шаардлагатай.
- 7.8. Суурин тоглоомын загвар болон эд ангийн хэмжээг MNS 6558:2015 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчны өрөнхий шаардлага стандартаас дэлгэрэнгүй үзнэ үү.
- 7.9. Тоглоом суурилуулах заавар, угсрах арга нь шошго, эсхүл түүнийг дагалдах бичигт тусгагдсан байдаг тул заавал танилцах шаардлагатай. Савлуур болон хөдөлгөөнт суурин тоглоомыг угсарч, суурилуулахдаа дараа зааврыг баримтална. Үүнд:
- савлуур, хөдөлгөөнт тоглоомыг ямар нэгэн байгууламжаас дор хаяж 1,8 м зайд байрлуулах, эсхүл хашаа, гараш, байшин, хэц, унжсан салаа мөчир, угаалгын газрын шугам хоолой, цахилгааны утас зэрэгт саад учруулахгүй газар суурилуулах;
  - энгийн хэрэглээний үед болон санаандгүй тохиолдлоор буруу хэрэглэх явцад тулгуурын бусад элементэд өргөгдөх, бэхэлгээний хэрэгсэл мултарч хөмрөхөөс сэргийлэхийн тулд зангуу, гадас зэрэг бэхэлгээг хэрхэн суурилуулах, хөрсний бүтцийг онцгой анхаарах;
  - бүдрэх, тээглэх аюулыг багасгахын тулд зангуу, гадсыг газартай тэгшлэх эсхүл, газарт гүн суулгаж өгөх;
  - дүүжин даажин, савлуур, гулсуур, авирах шат зэрэг хөдөлгөөнт тоглоомуудын зааварт элс, хөөс, хаймар, модны холтос, үртэс зэрэг нь хэрхэн нөлөөлөх талаар тусгагдсан байгаатай урьдчилан заавал танилцах;
  - савлуурын дүүжлэх хэсэг нь бөх бат, уян материалыаар хийгдсэн, хүүхэд барихад тохиромжтой байх;
  - тоглоомыг битум, цемент зэрэг аливаа хатуу гадаргууд суурилуулж болохгүй болохыг анхаарна.
- 7.10. Савлуур, хөдөлгөөнт тоглоомын хөндлөвч, холбоос, зангуу зэрэг гол хэсгүүдийн засвар үйлчилгээг хийхдээ бүдүүвч зураг, хугацаа, зааварчилгааг мөрдлөг болгоно. Үүнд:
- эрэг, боолтыг чангалах;
  - бүх металл хөдөлгөөнт хэсгүүдийг тослох;
  - хурц ирмэгтэй боолт, эргийн гадаргууг далдлах, шаардлагатай бол солих;
  - савлуурын сандал, гинж, олс болон бусад хавсарга эд ангиудын муудсан эсэхийг шалгах шаардлагатай бол үйлдвэрлэгчийн зааврын дагуу солих;
  - зэвэрсэн эд ангиуд, хоолойг өнгөлж цэвэрлэх шаардлагатай бол хар тугалга агуулаагүй будгаар будах гэх мэт.


## 8. БИЕИЙН ТАМИРЫН ТАЛБАЙ

- 8.1. Цэцэрлэгийн эзэмшил газарт тоглоомын талбай байхаас гадна хүүхдийн бие бялдрын өсөлт хөгжлийг хангах, дасгал хөдөлгөөн хийх, сургалтын үйл ажиллагаа зохион байгуулахад зориулагдсан биеийн тамирын талбайг байгуулна.
- 8.2. Биеийн тамирын талбайг хүүхдийн тооноос хамаарч нэг хүүхдэд ноогдох талбай 1м2 ба нэг талбайн хэмжээ 150 м2-250 м2 байхаар төлөвлөнө.
- 8.3. Биеийн тамирын талбайн тоног төхөөрөмжийг тогтмол засан сэлбэж, талбайд хүүхэд бэртэж гэмтэхээс сэргийлэн зүлэг, элс, зөөлөвч шалавч зэргийг хийж өгнө.
- 8.4. Биеийн тамирын талбайд хүүхдийн нас, биеийн онцлогийг харгалзсан, хөдөлгөөнийг дэмжсэн тоглоомын орчин бүрдүүлж өгөх хэрэгтэй.
- 8.5. Тоглоомын талбай дахь бүх тоног төхөөрөмжийн хоорондох зайд 2-6 метр зйттай байна. Үүнд:
  - уртын харайлтын замын өргөн – 1,5-2 м, урт 8-10 м, замын төгсгөлд газардахад зориулж 3м урт, 1,5-2 м өргөн, 30x40 см гүнтэй нүх бэлтгэж, нүхний дотор талыг элсээр дүүргэнэ;
  - хөл бөмбөгийн талбайн урт – 18 м, өргөн 12 м хэмжээтэй зүлэгжүүлсэн талбай байна. хөл бөмбөгийн хаалга нь гадна талбайд бат бөх тортой 2,5-3 м урттай, 1,5 м өндөртэй байна;
  - сагсан бөмбөгийн талбай – хэмжээ 7x13 м, сагсны шийд нь цагариг, тор самбар, тулгуур хөл зэргээс бүрдэнэ. шийдний цагаригийн диаметр 45 см, самбарын урт 120 см, өргөн 90 см байна. торыг газраас 180-200 см өндөрт байрлуулна. сагсны шийдийг гадаа талбайд бат бөх төмөр, modoор хийж, сайтар бэхэлсэн байна;
  - авиралтын шат – газраас 3-3,5 м өндөр, эгнээ бүрийг нь 65 см өргөнтэй, 6-8 эгнээтэй байрлуулна;
  - тэнцвэрийн вандан – сандлын урт 3 м, өргөн нь 20 см, өндөр нь 6-8 эгнээтэй байрлуулна.

## 9. БАРИЛГЫН ГОЛ ХААЛГА, ГАДНА ДОВЖОО

- 9.1. Цэцэрлэгийн орох, гарах хаалганы шат довжоо нь халтирахаас сэргийлэн хамгаалалтын хашлагатай байна. (Сургалт хүмүүжлийн байгууллагын барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах норм, дүрэм БНБД-II-6688)
- 9.2. Хашлаганы өндөр нь гурав ба түүнээс олон шаттай бол 0,8 метр хэмжээтэй байна.
- 9.3. Өнгөт хавтан, сайжруулан өнгөлсөн чулуу зэрэг нь халтиргааг үүсгэдэг тул цэцэрлэгийн гадна хаалга, довжоонд ашиглахгүй.
- 9.4. Цэцэрлэгийн барилгын гадна ба дотор шат нь хамгаалалттай, гэрэлтүүлэгтэй, шатны гишгүүрийн өндөр нь 27-30 см өндөр, өндөр 12-14 см, өргөн 1-2 метрээс багагүй байна.
- 9.5. Барилгын шатны хашлага нь зөвхөн босоо элементүүдээс бүрдэх бөгөөд хоорондын зайд нь 0,1 м-ээс ихгүй, үүдний шатны хашлаганы өндөр 0,8 м байхаар төлөвлөнө.

- 9.6. Барилгын гол хаалга нь хөгжлийн бэрхшээлтэй хүн ашиглах боломжтой 900 мм-ээс багагүй өргөнтэй байвал зохино.




Зураг 7. Шат болон бариулын хэмжээ (Жишээ зураг)


- 9.7. Цэцэрлэг нь барилгын үүдний хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч нарт зориулагдсан налуу замыг тавихдаа (MNS 6055 дараах шаардлагад нийцүүлсэн байна. Үүнд:

- налуу замын хоёр хажуу талаар 90 см-ээс багагүй өндөрт бариул бүхий хашлага хийнэ;
- бариулыг хоёр эгнээгээр байрлуулж, тэдгээрийн өндөр нь насанд хүрэгчдэд 70-90 см сургуулийн өмнөх насын хүүхдэд 50 см өндөртэй төлөвлөнө;
- налуу замын бариулын хийц, шатны бариулын хийцтэй адилхан байна;
- шатны бариулын хэмжээ нь дугуй хэлбэртэй бол диаметр нь 3-5 см, тэгш өнцөгт хэлбэртэй бол хөндлөн огтполын зузаан 4 см, хана бариул хоёрын хоорондох зайд 4,5 см байна;
- шатны гишгүүр дээр цэцэг болон бусад зүйлийг тавих, хэт зураг зурах зэрэг нь хүүхдийн анхаарлыг сарниулах аюулгүй зорчиход саад болно;
- хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн орж, гарах өрөө тасалгаа нь барилгын нэгдүгээр давхарт байрлана.

- 9.8. Шатны гишгүүр, налуу болон талбайд бариултай хашлага байна. Мөн өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан шатны нэмэлт бариулыг төлөвлөнө Шатны бариулын стандарт зайд хэмжээг Зураг 8-т үзүүлэв.




Зураг 8. Шатны нэмэлт бариулын стандарт (Жишээ зураг)



Зураг 9. Барилгын орц, гадна довжоо, налуу замын стандартт (Жишээ зураг)

## 10. ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖ

- 10.1. Хүүхдийн цэцэрлэг нь замын хөдөлгөөний дүрэмд зааснаар зам тээврийн хэрэгслийн хурд, хөдөлгөөний журмыг зохицуулах бүсэд харьяалагддаг тул явган зорчигчийн аюулгүй байдлыг хангасан байх.
- 10.2. Хүүхдийн цэцэрлэг орчмын бүсэд зам, замын байгууламжийг төлөвлөхдөө MNS 6423:2019, UCS 0901B:2020 стандарт, удирдамж аргазүйн баримт бичгүүдийг удирдлага болгосон байна.
- 10.3. Явган хүний зорчих өргөнийг (барилга байгууламжийн нүүрэн хэсэг, явган хүний зам, ногоон байгууламж) иж бүрэн төлөвлөх ба явган зорчигчдын хөдөлгөөний орон зайд хангалттай байна.



Зураг 10. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зогсоол, хүртээмжтэй зогсоолын хэмжээ (Жишээ зураг)



Зураг 11. Явган хүний зам (Жишиг зураг)


- 10.4. Зорчигчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор явган хүний замыг авто тээврийн хэрэгсэл зорчих хэсгээс тусгаарласан хаалт, хашилт, түмбэ суурилуулна. Үүнд:
- 10.5. Явган хүний замын сүлжээ буюу явган хүний зам нь тасралтгүй үргэлжилсэн байна;
- 10.6. Явган хүний зам нь бие даан хөдөлгөөнд оролцох чадвартай явган зорчигчдоос гадна бусдын тусламж, хараа хяналтад явдаг хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн зорчиход саадгүй буюу хүртээмжтэй байна.

## 11. ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

- 11.1. Цэцэрлэгийн бүсэд байрлах авто замд Монгол Улсын замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, холбогдох дүрэм, стандартад заасны дагуу тэмдэг, тэмдэглэгээ, хэрэгслийг заавал суурилуулна.
- 11.2. Цэцэрлэгийн хашааны гадна бүсэд тээврийн хэрэгслийн зогсоол байгуулсан тохиолдолд авто машины хөдөлгөөн зохицуулсан тэмдэг тэмдэглэгээг байрлуулах нь хүүхдийн аюулгүй байдлыг хангах нөхцөл болно.
- 11.3. Хүүхэд тэмдгийг цэцэрлэгийн ойр орчмын бүс болон бага насны хүүхдүүд байнга зам гардаг хэсэгт явган хүний гарц байгаа эсэхээс үл хамааран байрлуулна.
- 11.4. Тээврийн хэрэгслийн зогсоолын талбайд хөдөлгөөнийг хориглосон тэмдэг тэмдэглэгээ, хөдөлгөөн сааруулагч байрлуулахдаа замын хөдөлгөөний дүрэмд заасан тэмдэг, тэмдэглэгээний шаардлагыг хангасан байна.

Дараах тэмдэг, тэмдэглэгээг нийтлэг ашиглана:

 <p><b>Зураг 12. Сургууль орчмын бус 5.25 (Жишээ зураг)</b></p>	<p>Сургууль орчмын бус дотор тогтоосон хөдөлгөөний журмыг баримтлах нутаг дэвсгэрийг мэдээлнэ. Уг нутаг дэвсгэр рүү орох хэсэг бүрийн шууд өмнө байрлуулна. Сургуулийн бүсээс өмнө дор хаяж 200 мм-ийн наана байрлуулна.</p>
 <p><b>Зураг 13. Сургууль орчмын бус 5.26 (Жишээ зураг)</b></p>	<p>5.25 тэмдгээр тэмдэглэсэн нутаг дэвсгэр (замын хэсэг)-ээс гарч байгааг мэдээлэхэд хэрэглэнэ. Сургууль орчмын бус доторх огтлонцсон зам төгсөхөд (5.25, 5.26) тэмдгийг сургуулийн бүсэд түүш зам дээр Т хэлбэрийн уулзварын төгсгөлийн эсрэг талд байрлуулна.</p>
 <p><b>Зураг 14. Явган хүний гарц 5.19 (Жишээ зураг)</b></p>	<p>5.19.a, 5.19.б «Явган хүний гарц» тэмдгүүдийг зорчих хэсгээр явган зорчигч хөндлөн гарахад зориулсан газрыг мэдээлэхэд хэрэглэнэ. 5.19.a тэмдгийг замын зүүн гар талд, 5.19.б тэмдгийг баруун гар талд байрлуулна. Тэмдэглэлтэй гарц дээр 5.19.a, 5.19.б тэмдгийг тухайн гарцын хилээс 1м-ээс холгүй зайд байрлуулна .</p>
 <p><b>Зураг 15. Хурд сааруулагч 5.18 (Жишээ зураг)</b></p>	<p>Тээврийн хэрэгслийн хурдыг сааруулах зориулалт бүхий хиймэл бартааг мэдээлнэ. Хурд сааруулагчийн өмнө байрлуулна.</p>
 <p><b>Зураг 16. Хурд сааруулагч 1.17 (Жишээ зураг)</b></p>	<p>Зорчих хэсэг дээр тээврийн хэрэгслийн хурдыг сааруулах зориулалт бүхий хиймэл бартаа байгааг анхааруулна. Хурд сааруулагч тавигдсан газраас 50-100 метрт байрлуулна.</p>

 <p><b>Зураг 17. Хурдны хязгаар 2.24 (Жишээ зураг)</b></p>	<p>Сургуулийн бус дэх тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг өрөнхий боловсролын болон тусгай сургууль, цэцэрлэг ажиллах өдруүдэд, цагт 20 км/ц-аас хэтрүүлэхгүй байна.</p> <p>2.24 тэмдгүүдийн үйлчлэх хүрээ нь байрласан газраасаа эхний уулзвар хүртэл, уулзваргүй замд суурин газраас гарах хүртэл хүчинтэй байна.</p>
 <p><b>Зураг 18. Хүүхэд 1.19 (Жишээ зураг)</b></p>	<p>Зорчих хэсэг рүү хүүхэд гэнэт орж ирж болзошгүй хэсгийг анхааруулна.</p> <p>Замын зэргэлдээх сургуулийн орчны дэргэдүүр явж өнгөрөх замын хэсгийн өмнө болон бага наасны хүүхдүүд байнга зам хөндлөн гардаг хэсгийн өмнө явган хүний гарц байгаа эсэхээс үл хамааруулан байрлуулна.</p>
 <p><b>Зураг 19. Нэмэлт тэмдэг 7.2a (Жишээ зураг)</b></p>	<p>1.19 тэмдгийг давтан тавьж хэрэглэнэ. Давтан тавих тэмдгийг 7.2.a нэмэлт тэмдгийн хамт аюултай хэсгийн эхлэлийн шууд өмнө байрлуулах бөгөөд уг нэмэлт тэмдгээр тухайн хүүхдийн байгууллагын орчны дэргэдүүр явж өнгөрсөн замын хэсэг буюу хүүхдүүд байнга зам хөндлөн гардаг хэсгийн үргэлжлэх зайл заана.</p>
 <p><b>Зураг 20. Унадаг дугуйн зам нийлнэ 1.20 (Жишээ зураг)</b></p>	<p>Унадаг дугуйн замтай огтлолцсон хэсэгт ойртох байгааг анхааруулна.</p> <p>1.20 тэмдгийг 4.4 тэмдэг бүхий унадаг дугуйн зам (уулзвараас өөр хэсэгт) зорчих хэсэгтэй огтлолцсон бэлчрийн өмнө байрлуулна.</p>
 <p><b>Зураг 21. Унадаг дугуйн зам 4.4 (Жишээ зураг)</b></p>	<p>Зөвхөн унадаг дугуй, мопедын хөдөлгөөнийг зөвшөөрөхөөс гадна Замын хөдөлгөөний дүрмийн 5.1-д заасны дагуу явган зорчигчийн хөдөлгөөнийг мөн зөвшөөрнө.</p>

## 12. АЮУЛГҮЙ БАЙДАЛ, КАМЕРЖУУЛАЛТ

- 12.1. Цэцэрлэгийн гадна болон дотор орчинд багш, албан хаагчид, хүүхдүүдийн аюулгүй байдлын хэрэгцээ, хувийн болон нийтийн өмч хөрөнгийг хамгаалан аюулгүй байдлыг хангаж, гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх шаардлагатай.
- 12.2. Барилгын онцлог, талбайн хэмжээ, ашиглах хэрэгцээ, шаардлага зэргээс шалтгаалан камерын байрлал, хүчин чадал зэргийг сонгож хэрэглэнэ.
- 12.3. Камерыг суурилуулахдаа харагдах талбайн өнцөг, урт өргөн, ханын байрлал, талбайн өргөн хэмжээгээр тод харах цэг, бичлэг хийх хугацаа зэргийг тооцоолно.
- 12.4. Дууны, дүрсний, мэдээллийг цуглуулах, хадгалах, ашиглах боломж бүхий хөдөлгөөнт болон суурин дүрс бичлэгийн техник, хэрэгсэл нь Монгол Улсын “Барилга, орон сууц, гудамж талбайд тавих хяналтын камер, Ерөнхий шаардлага MNS 6423:2013/, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1.6-т заасан шаардлага болон олон улсын “IP67 стандарт”-д нийцсэн байна.
- 12.5. Хяналтын камер байршуулсан газруудад таних тэмдгийг байршуулах шаардлагатай бөгөөд олон улсад хэрэглэгддэг тэмдэглэгээг ашиглана.



Зураг 22.Хяналтын камер тэмдэг (Жишээ зураг)

## 13. ҮЕРЭЭС ХАМГААЛАХ, БОРООНЫ УС ЗАЙЛУУЛАХ БАЙГУУЛАМЖ

- 13.1. Нийгмийн дэд бүтцийн барилга байгууламж буюу бүх төрлийн цэцэрлэг, сургууль, эмнэлгийн барилгыг барьж байгуулахад “Үерээс хамгаалах байгууламжийг төлөвлөх удирдамж” -ийг мөрдлөг болгоно.
- 13.2. Үерийн эрсдэл бүхий газар, голын сав, үерийн усны урсац бүрэлдэх газарт нийгмийн дэд бүтцийн барилга байгууламжийг барьж байгуулахыг хориглох бөгөөд тус барилга байгууламжийг эрсдэл багатай бүсэд байгуулна.



Зураг 23. Нийгмийн дэд бүтцийн барилга байгууламжийн төлөвлөлт (Жишээ зураг)

- 13.3. Аливаа барилгажилтын үйл ажиллагаа нь үерийн нөлөөллийг эрчимжүүлэх ёсгүй бөгөөд барилга байгууламж төлөвлөх нутаг дэвсгэрийн үнэлгээний хүрээ, арга технологийг тогтоож, үерийн гамшигт автах эрсдэлийг бууруулж борооны ус зайлцуулах байгууламжийг төлөвлөнө (Зураг 13).
- 13.4. Барилга, зам, талбайн үерээс хамгаалах болон борооны ус зайлцуулах барилга, байгууламжийн засвар үйлчилгээг тогтмол хийж, шаардлагатай нөхцөлд шинэчлэн сайжруулж өргөтгөх шаардлагатай.
- 13.5. Төлөвлөлтийг гүйцэтгэхдээ иргэд болон онцгой байдлын албан хаагчдад учирч болох үерийн эрсдэлийг аюулгүйн хэмжээнд байлгах, барилга байгууламж түүнд холбогдох дэд бүтцэд үерийн хохирол учрахаас сэргийлэх эсхүл болзошгүй хохирлыг багасгахаар тооцож төлөвлөнө. (Зураг 14).




Зураг 24. Үерээс хамгаалах борооны ус зайлцуулах байгууламжийн төлөвлөлтийн менежмент (Жишээ зураг)

## 14. ХАШАА, ХАЙС

- 14.1. Цэцэрлэгийн эзэмшил газрыг хамгаалж тусгаарласан хашаа барьж байгуулахдаа аюулгүй байдлыг хангахын зэрэгцээ цэцэрлэгийн онцлог байдал, хүүхдийн танин мэдэхүй, сонирхолд нийцсэн загвар, өнгө, хийцтэй байхад анхаарна.
- 14.2. Хашааг тоосго, блок, мод, төмөр зэрэг материалыар бат бөх барьж байгуулна. Дээрх зөвлөмжийн дагуу хашааг барихад анхаарах нийтлэг зүйлсийг анхаарна. Үүнд:
  - модон материалыар хийсэн хашааны шонгийн голч 14 см байх, газарт 1 м-ээс багагүй гүнд суулгах;
  - хашааны босоо сараалж хоорондох зайд 10 см байхаар тооцож, сараалжны завсраар хүүхэд шургах, мал амьтан орж, гарахаас сэргийлэх;
  - хашааны өндөр нь тогтоосон хэмжээнд хүрэхгүй байгаа тохиолдолд суuriийг өндөрлөх, өргөн нь 30 см-ээс багагүй байх;
  - орон нутгийн онцлог нөхцөлд тохируулан хашааны өндрийг 0,4 м-ээс ихэсгэхийг зөвшөөрнө.

- 14.3. Хашааны оройн хэсэг нь хурц, шовх үзүүртэй, явган зорчигчийн хаалгыг эргэдэг, дээрээ хөндлөвчтэй, хаах татуургыг пүрш, сунах материалаар хийхгүй.
- 14.4. Явган зорчигчийн хаалганы хөндлөвчийг насанд хүрэгчийн өндрийн хэмжээнд тохируулах, эсхүл хөндлөвчгүй, зориулалтын татуургатай, зөвхөн нэг зүгт онгойдог байхаар төлөвлөнө.
- 14.5. Цэцэрлэгийн хашаанд түргэн тусламж, галын машин саадгүй нэвтрэх хаалгыг явган зорчигч орох, гарах хаалганаас тусад нь төлөвлөж байгуулна.



Зураг 25. Хашаа хайсны төрөл (Жишээ зураг)

## 15. ЗАМ ТАЛБАЙН ГЭРЭЛТҮҮЛЭГ

- 15.1. Эзэмшил газрын гэрэлтүүлгийг цэцэрлэгийн барилгын бүхий л хэсэгт жигд тарах, зам гарцыг гэрэлтүүлэхээр доошоо гэрэлтдэг байхаар төлөвлөж байрлуулна.
- 15.2. Гэрлийн шонгийн өндөр, хоорондын зай, гэрлийн хүчин чадал зэргийн үзүүлэлтийг тооцож гэрэлтүүлгийг төлөвлөнө.
- 15.3. Гэрэлтүүлгийг барилгын дээвэр, хана дээр байрлуулж болох бөгөөд гэрэл ойлгогч материалтай хослуулж хэрэглэж болно.
- 15.4. Нарны эрчим хүчээр ажилладаг гэрэлтүүлэг хийхэд тухайн бүс нутгийн нарны хоногийн тухай мэдээллийг авч түүнтэй уялдуулан бусад эх үүсвэрийн гэрэлтүүлгийн ашиглана.
- 15.5. Гэрэлтүүлгийн төрөл ангилал, ган багана, өнгө, суурилуулах техник зэргийг Монгол Улсын үндэсний стандарт “Гэрэлтүүлгийн ган багана. Техникийн шаардлага” MNS2568 болон “Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд байршуулах гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжид тавих шаардлага” UCS 1901B-ийн мөрдлөг болгоно.



Зураг 26. Гадна орчны гэрэлтүүлэг (Жишээ зураг)

## 16. БАЙГУУЛЛАГЫН НЭРИЙН ТЭМДЭГ, БАЙРШЛЫН МЭДЭЭЛЭЛ



- Байгууллагын төрөл:** Бүх төрлийн сургууль, цэцэрлэг
- Самбар:** Хөх цэнхэр өнгөтэй
- Бичвэр:** Цагаан өнгөтэй
- Материал:** Нерж материалтай

Зураг 27. Байгууллагын нэрийн тэмдэг (Жишээ зураг)

### Барилга байгууламжийн нэрийн бичвэр

- 16.1. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага нь гадна хана, дээврийн хэсэгт өөрийн нэрийг том хэмжээгээр бичих буюу биет хэлбэрээр байрлуулж болох бөгөөд нэрийн бичвэрт “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавих өрөнхий шаардлага” MNS 5283 (Зураг 18).



*Зураг 28. Байгууллагын нэрийн бичвэр (Жишээ зураг)*

- 16.2. Барилгын гадна талд байрлуулах байгууллагын нэрийн бичвэрийг “Монгол хэл бичгийн боловсролыг сайжруулах арга хэмжээний тухай” (ЗГ-ын 37-р тогтоол, 2013 он) тогтоолын дагуу Монгол хэл /кирилл/-ээр үг, үсгийн алдаагүй бичих бөгөөд Монгол бичиг /уйгуржин/-ээр бичиж болно.

## 17. ХОГ ХАЯГДАЛ ЦУГЛУУЛАХ ЦЭГ

- 17.1. Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1.3-д заасны дагуу хог хаягдлыг хаяхдаа ангилан ялгах үүрэгтэй бөгөөд ялгах таних тэмдгийг зөв ашиглах нь аливаа хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах үйл ажиллагаанд чухал үүрэгтэй.
- 17.2. Цэцэрлэгийн хог хаягдал түр хадгалах цэг нь хана, хашаагаар тусгаарласан хаалттай, битүүмжлэл сайтай, хог ангилж хийх боломжтой, сургуулийн барилга байгууламжаас 30 метрээс, усны эх үүсвэрээс 100 метрээс багагүй зайд зонхилох салхины доод зүгт байрлана (MNS 6782:2019, 5.6).
- 17.3. Хог хаягдал цуглуулах цэг рүү цэцэрлэгийн эдэлбэр газарт орох хог ачих зориулалт бүхий тусдаа орц гарцтай байхаар төлөвлөнө (Зураг 29).
- 17.4. Хог хаягдал цуглуулах цэгт байх хогийн саванд хог хаягдлыг ангилан хаях бөгөөд ангиллын дагуу өнгө, тэмдэг, тэмдэглэгээтэй байна.
- 17.5. Хог хаягдал цуглуулах савнууд нь цаасан дахивар болон бусад хог хаях зориулалтыг заасан олон улсад хэрэглэгддэг мэдээлэх тэмдэгтэй байх ба хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн байх шаардлагатай (Зураг 30).
- 17.6. Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавих өрөнхий шаардлага (Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2018 оны А/443 дугаар тушаал)-ын дагуу ангилж, MNS 5344:2011 стандартын дагуу тээвэрлүүлнэ.



Зураг 29. Хог хаягдал цуглуулах цэг (Жишээ зураг)



Зураг 30. Ангилан ялгах тэмдэг бүхий хогийн сав (Жишээ зураг)

- 17.7. Энгийн хог хаягдлыг зориулалтын, битүүмжлэлтэй, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ (Хог хаягдлын тухай хууль 14.6). Хог ачих талбай тэгш гадаргуутай, хонхор гүдгэргүй, хучилттай, автомашин ба механизм эргэх, тойрох, өргөх хөдөлгөөн хийхэд саадгүй байлгана. (MNS 5344:2011, 7.3).


## 18. ГАМШГААС ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

- 18.1. Цэцэрлэгийн барилга нь багш, албан хаагч, суралцагч хүүхдүүдийн эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд аюул учруулахгүй, бат бэх тогтвортой, галын аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, хор хөнөөлийг хязгаарлах нөхцөлийг хангана.
- 18.2. Барилга байгууламж, тээврийн хэрэгсэл гол түймэр унтраах анхан шатны багаж, хэрэгслээр хангагдсан байна. Анхан шатны багаж, хэрэгслийг өөр зориулалтаар ашиглахыг хориглоно (Галын аюулгүй байдлын тухай хууль 19.3), (Зураг 21).

*Хүснэгт 3. Гол унтраах анхан шатны багаж.*

	
Зураг 31. Галын дохиолол (Жишээ зураг)	Зураг 32. Ослын гарц (Жишээ зураг)
	
Зураг 33. Галын гидрант (Жишээ зураг)      Зураг 34. Хүрз, лом (Жишээ зураг)	
	
Зураг 35. Галын хор (Жишээ зураг)	

- 18.3. Сургууль, цэцэрлэгийн барилга байгууламж нь цахилгаан хангамж, эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй байх бөгөөд аянга зайлцуулагч газардуулгатай байна (MNS 6782:2019).
- 18.4. Сургууль, цэцэрлэгийн барилгын дээвэр дээр харилцаа холбооны антен, тоног төхөөрөмж байрлуулахыг хориглоно. (MNS 6782:2019).
- 18.5. Болзошгүй газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах, иргэд олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор нийслэлийн нутаг дэвсгэрт гамшгийн үед түр цугларах цэгийг гадна талбайд төлөвлөнө. Сургууль, цэцэрлэгийн бүсэд цугларах талбай нь амрах талбай байж болох бөгөөд цугларах талбайн таних тэмдгийг Зураг 22-д үзүүлэв.



Зураг 36. Түр цугларах аюулгүй талбай тэмдэг, сууринуулах схем

## 19. ХҮЛЭЭН АВАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын гадна орчны төлөвлөлтийн шаардлага хангаж байгаа эсэхийг дараах шалгуур үзүүлэлт (Хүснэгт 4)-ийн дагуу хянан шалгана.

*Хүснэгт 4. Шалгуур үзүүлэлт*

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Сургуулийн өмнөх боловсролын байгууллага нь өөрийн эзэмшил газартай, гэрчилгээ, кадастрын зургаар баталгаажсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилга байгууламж нь сургалтын хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөл, боломжоор хангагдсан зориулалтын байртай эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилга байгууламж, эзэмшил газар нь стандартын шаардлага хангасан хашаатай, түүнийг зориулалтын дагуу ашигладаг эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Орох, гарах, хаалганы шат довжоог халтиргаанаас хамгаалсан, мөн хаалганы гадна орчинд цардсан талбайтай эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Барилгын дотор болон гадна талд стандартын дагуу төле хяналтын камер суурилуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Цэцэрлэг нь аюулгүй байдлын дохиоллын систем, галын дүгнэлт, аянга зайлнуулагчтай эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7	Барилга байгууламжийн нэрийн бичвэр, үл хөдлөх хөрөнгийн хаяг, хаягийн байгууламж нь (зай, хэмжээ, үзэгдэх орчны нөлөө, суурилуулалт) шаардлага хангасан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
8	Явган хүний зам стандартын шаардлага хангаж байгаа эсэх (материалын чанар, зай хэмжээ, замын суурь, бэхэлгээ)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
9	Унадаг дугуйн зам болон зогсоол нь стандартын шаардлага хангаж байгаа эсэх (замын хучилт, өнгө, тэмдэглэгээ, зай хэмжээ)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
10	Ногоон байгууламж стандартын шаардлага хангаж байгаа эсэх (ногоон байгууламжийн газрын хэмжээ, ногоон байгууламжийн төрөл зүйл, хар хөрсний хэмжээ)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
12	Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө нь стандартын шаардлага хангаж байгаа эсэх (саравч, сүүдрэвч, сандал, хогийн саванд тавих шаардлагын дагуу)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
13	Авто зогсоолын талбай нь стандартын шаардлага хангаж байгаа эсэх (замын хучилт, замын суурь, хөдөлгөөний аюулгүй байдлын тэмдэг, тэмдэглэгээ, зай хэмжээ, нэмэлт тоноглол, орц гарц)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
14	Хог хаягдал цуглуулах цэг нь стандартын шаардлага хангаж байгаа эсэх (хог цуглуулах сав, ачих талбай, орц гарц, зай хэмжээ)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

### Тайлбар:

- Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын төлөвлөлт нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол “**Тийм**” хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол “**Үгүй**” хэсгийг тэмдэглэнэ.
- Бусад тохижилт бүтээн байгуулалтад хамаарах зүйлсийг Хотын стандартын баримт бичгийн тогтолцоонд хамаарах хүлээн авах шалгуурын дагуу шалгаж хүлээн авна.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Боловсролын тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
- Хог хаягдлын тухай хууль
- Галын аюулгүй байдлын тухай хууль
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль
- Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30.01.04
- Олон нийт, иргэний барилгын норм БНБД 31.03.03
- Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчин. Ерөнхий шаардлага MNS 6558:2015
- Сургалт хүмүүжлийн байгууллагад мөрдөх эрүүл ахуй, халдварт хамгааллын үлгэрчилсэн дүрэм /Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2017 оны А/179 дүгээр тушаал/
- Хүүхдийн цэцэрлэгийн аюулгүй байдлын дүрэм /БСШУС-ын тушаал/
- Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавих шаардлага
- Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага /Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 11 дүгээр сарын 17 өдрийн А/443 дугаар тушаал/;
- Гадна зар сурталчилгаанд тавих шаардлага /Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016 оны 9/10 дугаар тогтоол/;





Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг  
ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР



Хан-Уул дүүрэг, 23-р хороо, 17100, Наадамчдын зам  
1200, Нутгийн захиргааны цогцолбор байр.



70118030, 70118040



[www.standard.ub.gov.mn](http://www.standard.ub.gov.mn)



Хотын стандарт, хяналтын газар